



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/585

Мөрөн сум

Зохион байгуулалтын арга хэмжээ
авч хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.3 “а”, 29.1.6-ийн “а”, 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, Улсын Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний 12 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний 39 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын шуурхай штабын үйл ажиллагааг идэвхжүүлж, бэлэн байдлыг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт, сумын Онцгой комисс түүний шуурхай штабын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ё.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

2. Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 09 цагаас мөн оны 11 дүгээр сарын 13-ны өдрийг дуустал хугацаанд түр зогсоосугай.

3. Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг түр зогсоож байгаатай холбогдуулж 0-5 насны хүүхэдтэй албан хаагчдадаа байгууллагын хүний нөөцийн нөхцөл боломжтой уялдуулж, цалинтай чөлөө олгохыг аж ахуй нэгж, байгууллагын удирдлагуудад зөвлөсүгэй.

4. Архи согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулах үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 09:00 цагаас мөн оны 11 дүгээр сарын 13-ны өдрийг дуустал хугацаанд зогсоосугай.

5. Аймгийн хэмжээнд урлаг соёлын үзвэр үйлчилгээ, РС тоглоом, бүжгийн клуб, биллиард, спорт заал, фитнес болон бусад олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахыг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 09:00 цагаас мөн оны 11 дүгээр сарын 13-ны өдрийг дуустал хугацаанд зогсоосугай.

6. Хот хоорондын болон орон нутгийн зорчигч тээврийн үйл ажиллагааг хяналтад авч, халдвар хамгааллын дэглэм сахиулж ажиллахыг аймгийн Онцгой комиссын шуурхай штаб, аймгийн Цагдаагийн газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн төв, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

01111136

2.

7. Улсын Онцгой комиссын 2020 оны 10 дугаар сарын 19-ны 04 дүгээр албан даалгавар "Маскаа зүүцгээе, гараа угаая" аяны хэрэгжилтийг хангаж, Ковид-19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг идэвхжүүлж, халдвар хамгааллын дэглэм сахиулж ажиллахыг сумдын Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад даалгасугай.

Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

